



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/152/СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч : Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг: zayag@audit.gov.mn Аудитор:Ц.Алтантуул Утас: 91195554 Цахим хаяг : tuul9565@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт .....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12

2022.09.21 № 1302/88

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЭРДЭНЭХАЙРХАН СУМЫН  
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Р.ЦЭЭЦЭГМАА-д

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэхайрхан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэхайрхан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013022980

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	31.36	38.28
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	31.36	38.28
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	11.81	13.28
35110	Тусгай зориулалттай материал	11.11	12.47
35130	Эм боох материал	0.70	0.82
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	19.55	24.99
35410	Бичиг хэргийн материал	0.67	1.47
35420	Аж ахуйн материал	9.85	10.91
35440	Түлш, шатах тослох материал	1.00	3.00
35460	Хүнсний материал	4.80	6.35
35470	Бусад хангамжийн материал	3.24	3.27
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	277.47	268.82
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	277.47	268.82
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	272.88	264.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	261.87	261.87
39202	Хуримтлагдсан элэгдэл	(7.00)	(20.27)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	18.72	27.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11.36)	(13.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8.37	9.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7.44)	(7.63)
39214	Бусад үндсэн хөрөнгө	38.06	38.06
39215	Хуримтлагдсан элэгдэл	(29.02)	(31.99)
39217	Ном	0.69	0.69
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	4.59	4.26
39301	Програм хангамж	1.85	1.85
39302	Хуримтлагдсан элэгдэл	(0.20)	(0.53)
39303	Бусад биет бус хөрөнгө	2.94	2.94
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	308.83	307.10
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	308.83	307.10
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	308.83	307.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	49.32	49.32
51101	Өмч: - төрийн	49.32	49.32
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	201.29	199.57
51210	Өмнөх үеийн үр дүн	201.29	201.29
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1.73)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	58.21	58.21
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	308.83	307.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/сая төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	385.42	197.66
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	198.91	1.20
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	198.91	1.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	198.91	1.20
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	198.91	1.20
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	186.51	196.46
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	171.22	168.91
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	171.22	168.91
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	15.29	21.94
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15.29	21.94
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	-	5.61
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	5.61
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	187.38	199.39
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	187.38	199.39
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	166.66	193.78
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	110.64	121.67
210101	Үндсэн цалин	110.64	121.67
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14.19	15.89
210201	Тэтгэврийн даатгал	9.51	11.06
210202	Тэтгэмжийн даатгал	1.17	1.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.93	0.97
210204	Ажилгүйдлийн даатгал	0.23	0.24
210205	Эрүүл мэндийн даатгал	2.34	2.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	17.08	19.24
210301	Гэрэл, цахилгаан	0.57	0.73
210302	Түлш, халаалт	16.51	18.50
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3.65	4.34
210401	Бичиг хэрэг	0.66	0.61
210402	Тээвэр, шатахуун	1.12	1.18
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.96	0.78
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.92	1.77
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	11.57	11.37
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.95	1.12
210502	Хоол, хүнс	10.62	10.25
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	0.71
210604	Урсгал засвар	-	0.71
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.58	0.70
210702	Дотоод албан томилолт	0.58	0.70

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.71	0.42
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	0.42
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8.25	19.45
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.42	0.92
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7.83	18.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20.72	5.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	1.60	5.61
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	5.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	198.04	(1.73)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	195.16	(1.73)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /сая төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	49.32	58.21	7.78	115.32
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1.65)	(1.65)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	49.32	58.21	6.13	113.66
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	195.16	195.16
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	49.32	58.21	201.29	308.83
D01	2021 оны 01-р сарын 1-нээрх үлдэгдэл	49.32	58.21	201.29	308.83
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	49.32	58.21	201.29	308.83
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(1.73)	(1.73)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	49.32	58.21	199.57	307.10

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/сая төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	186.51	196.46
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	186.51	196.46
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	171.22	168.91
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	171.22	168.91
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	15.29	21.94
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15.29	21.94
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	-	5.61
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	5.61
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	182.56	187.46
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	182.56	187.46
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	161.85	181.85
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	110.64	121.67
210101	Үндсэн цалин	74.90	66.83
210102	Нэмэгдэл	25.05	44.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.50	0.50
210104	Урамшуулал	10.20	10.27
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14.19	15.89
210201	Тэтгэврийн даатгал	9.51	11.06
210202	Тэтгэмжийн даатгал	1.17	1.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.94	0.97
210204	Ажилгүйдлийн даатгал	0.23	0.24
210205	Эрүүл мэндийн даатгал	2.34	2.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14.58	21.24
210301	Гэрэл, цахилгаан	0.57	0.73
210302	Түлш, халаалт	14.01	20.50
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3.62	5.18
210401	Бичиг хэрэг	0.62	1.41
210402	Тээвэр, шатахуун	1.16	0.86
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.80	0.78
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1.00	2.13
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	15.77	14.81
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2.30	1.87
210502	Хоол, хүнс	11.87	11.81
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1.61	1.13
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	0.71	0.71
210604	Урсгал засвар	0.71	0.71
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.30	0.70

210702	Дотоод албан томилолт	0.30	0.70
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	0.80	0.42
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	0.42
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1.23	1.24
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1.23	1.24
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	20.72	5.61
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1.60	5.61
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	5.61
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	3.95	9.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	3.95	9.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	3.95	9.00
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	3.95	9.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3.95	9.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	(3.95)	(9.00)

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ сая төгрөгөөр /

		<b>Батлагдсан төлөвлөгөө</b>	<b>Гүйцэтгэл</b>
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	191.74	190.85
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	191.74	190.85
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	191.74	190.85
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	121.67	121.67
210101	Үндсэн цалин	80.66	66.83
210102	Нэмэгдэл	31.13	44.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.50	0.50
210104	Урамшуулал	9.39	10.27
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	15.89	15.89
210201	Тэтгэврийн даатгал	11.06	11.06
210202	Тэтгэмжийн даатгал	1.21	1.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.97	0.97
210204	Ажилгүйдлийн даатгал	0.24	0.24
210205	Эрүүл мэндийн даатгал	2.42	2.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	21.24	21.24
210301	Гэрэл, цахилгаан	0.90	0.73
210302	Түлш, халаалт	19.54	20.50
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5.18	5.18

210401	Бичиг хэрэг	0.62	1.41
210402	Тээвэр, шатахуун	1.16	0.86
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.80	0.78
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2.56	2.13
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>15.70</b>	<b>14.81</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1.87	1.87
210502	Хоол, хүнс	12.70	11.81
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1.13	1.13
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.71</b>	<b>0.71</b>
210604	Урсгал засвар	0.71	0.71
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>0.59</b>	<b>0.70</b>
210702	Дотоод албан томилолт	0.59	0.70
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>0.42</b>	<b>0.42</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.42	0.42
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10.35	10.24
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>191.74</b>	<b>190.85</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>169.80</b>	<b>168.91</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	169.80	168.91
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>21.94</b>	<b>21.94</b>
132001	Орон нутгийн төсвөөс	21.94	21.94
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>9.00</b>	<b>9.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	04.00	04.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/сая төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		5.61
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		5.61
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	0.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		5.61
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		5.61

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрдэнэхайрхан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер Аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Эрдэнэхайрхан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Эрдэнэхайрхан сумын хүүхдийн цэцэрлэг нь Хүүхдийн хөгжлийг дэмжих суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэхайрхан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 191.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 2.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр	Тайлант оны эхний үлдэгдэл	Тайлант оны эцсийн үлдэгдэл	Зөрүү
1	БАРАА МАТЕРИАЛ	31,359.06	38,277.24	(6,918.18)
2	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	277,466.80	268,821.76	8,645.04
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	308,827.86	307,099.00	1,728.86
4	Засгийн газрын хувь оролцоо	308,827.86	307,099.00	1,728.86
5	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	308,827.86	307,099.00	1,728.86

Бараа материалын данс 6,918.1 мянган төгрөгөөр өссөн нь цаг үеийн шаардлагаар махны худалдан авалтыг хийсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,645.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардалтай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,728.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 191,740.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 191,740.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 168,907.2 мянган төгрөгийн орон нутгийн төсвөөс 21,944.1 мянган төгрөгийн нийт 190,851.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 190,851.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 5,609.4 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлэн, 5609.4 мянган төгрөгийн хөдөө орон нутгийн тэтгэмжинд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

## **3.8 Аудитын гол асуудал**

Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй, нягтлан бодогчийн цалингаас ХХОАТ суутгаагүй олгосон.

## **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 122 мэдээлэл, хугацаа хоцроосон 27 мэдээлэл байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэхэд шилэн дансанд мэдээлэл байршуулахдаа хугацаа хоцроосон байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

## **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

## **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Хоолны зардал, хоолны материалын үлдэгдлийн зарцуулалтыг анхаарах

---

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 0.9 сая төгрөгийн зөрчил илрүүлэн, 0.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 0.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

##### 4.1 Залруулсан алдаа байхгүй

##### 4.2 Төлбөрийн акт

Нягтлан бодогчийн цалингаас 0.2 сая төгрөгийн ХХОАТ суутгаагүй олгосныг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

##### 4.3 Албан шаардлага хүргүүлээгүй

##### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

- ✓ 0.7 сая төгрөгийн гүйлгээг няравын түр дансаар дамжуулсан, бэлэн мөнгөний гүйлгээний тайланг гаргаагүй байна.
- ✓ Шилэн дансны мэдээлэл хугацаанд нь оруулаагүй.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлэн ажиллах;
- ✓ Эд хариуцагчид бэлэн мөнгөний гүйлгээний тайланг цаг тухайд нь гаргаж хэвших үүргийг хүргүүлэн, биелэлтийг тооцож, хянах;
- ✓ Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.	Эрдэнэхайрхан сумын хүүхдийн цэцэрлэг	3	0.9			1	0.2			2	0.7
	<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>0.9</b>			<b>1</b>	<b>0.2</b>			<b>2</b>	<b>0.7</b>

